



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/81/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа

Утас: 70584207 Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
Менежментийн захидал.....	13
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.20 № 115

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520036



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Должин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв. Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дэвшилтэт технологи, шинэ мэдлэгт суурилсан, ёс зүйтэй, сэтгэлд нийцсэн тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, үр дүнтэй, тэгш үзүүлнэ.”

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд хүргэх, эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэшлийн оношилгоо эмчилгээний лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа явуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 9,080,269.2 мянган төгрөгөөс тооцон 181,605.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 219,954.2 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант онд санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,668,018.3 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	756,360.7	783,065.2	26,704.5
Үндсэн хөрөнгө	17,429,427.5	20,016,465.4	2,587,037.9
Хуримтлагдсан элэгдэл	-6,843,729.6	-7,789,453.7	-945,724.1
Нийт хөрөнгө	11,342,058.6	13,010,076.9	1,668,018.3
Өр төлбөр	47,406.4	10,406.0	-37,000.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,294,652.2	12,999,670.9	1,705,018.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,342,058.6	13,010,076.9	1,668,018.3

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Глобал сангийн хөтөлбөрөөр 39.8 сая төгрөгийн эм тариа, эмнэлгийн хэрэгсэл үнэ төлбөргүй нийлүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант жилд улс, орон нутгийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.0 тэрбум төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 65.0 сая төгрөг, гадаадын хөрөнгө оруулалтаар 491.9 сая төгрөг, нийт 2,556.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 30.1 сая төгрөгийн тоног, төхөөрөмж, тавилга худалдан авсан дүнгээр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийг бууруулах ажил гүйлгээ гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,999,670.9 мянган төгрөг болж 1,705,018.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын орлого нь элэгдлийн зардлаас их байгаагаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого

/мян.төг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
Төсөвт байгууллагын өөрийн орлого	208,500.0	208,506.2	6.2	100.0



Нийт дүн	208,500.0	208,506.2	6.2	100.0
----------	-----------	-----------	-----	-------

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 9,613,291.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 9,613,291.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 9,613,291.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: ЭМЯ, ЭМДЕГ, аймгийн ЭМГ болон төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос чихрийн шижин, багц үзлэг, урсгал зардалд зориулан нийт 255,791.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 200,490.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,252.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 184,831.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 10,406.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг тус тус өглөө.

Аудитаар дараах 200,490.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 190,084.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цалингийн зардлыг шалгахад ажилтанд тусгайлан заагдаагүй 40.0 хувийн нэмэгдэл олгож 3,687.4 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолтой нийцэхгүй байгаа бөгөөд 2019 оны цалингийн тушаалд уг нэмэгдлийг олгохоор тусгагдаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант оны эцэст 1564.7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Нийт худалдан авалтын 7.0 хувь буюу 184.8 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь Е-баримтад бүртгэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-тай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.



Аудитаар 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Оны эцэст 10,406.0 мянган төгрөгийн өр, төлбөрийн үлдэгдэлтэй ажилласан байна.

1.2 Эрсдэл: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах.

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	756 360 684,33	783 065 224,54
35	БАРАА МАТЕРИАЛ	756 360 684,33	783 065 224,54



351	Түүхий эд материал	694 014 084,33	722 206 236,49
35110	Тусгай зориулалттай материал	493 307 529,70	603 465 090,70
35130	Эм боох материал	200 706 554,63	118 741 145,79
354	Хангамжийн материал	49 606 600,00	44 798 988,05
35410	Бичиг хэргийн материал	3 333 388,00	1 169 830,00
35420	Аж ахуйн материал	15 620 888,00	15 620 888,00
35440	Түлш, шатах тослох материал	76 064,00	13 589,00
35450	Барилгын засварын материал	47 300,00	757 791,00
35460	Хүнсний материал	1 281 580,00	1 564 730,05
35470	Бусад хангамжийн материал	29 247 380,00	25 672 160,00
35600	Мал амьтад	12 740 000,00	16 060 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10 585 697 908,17</u>	<u>12 227 011 652,00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10 585 697 908,17	12 227 011 652,00
392	Биет хөрөнгө	9 445 737 657,62	11 087 284 318,72
39201	Барилга, байгууламж, орон сууц	7 854 352 338,00	8 483 152 338,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-140 988 954,60	-417 080 959,28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	918 438 340,00	918 438 340,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-874 531 654,14	-889 532 041,74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7 123 586 185,42	9 071 827 200,04
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5 597 640 555,96	-6 204 401 729,82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	347 318 167,55	357 314 967,55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-207 531 579,27	-251 078 712,01
39214	Бусад үндсэн хөрөнгө	43 543 756,00	43 543 756,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20 808 385,38	-24 898 840,02
393	Биет бус хөрөнгө	1 139 960 250,55	1 139 727 333,28
39301	Програм хангамж	2 963 750,00	2 963 750,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2 228 499,45	-2 461 416,72
39303	Бусад биет бус хөрөнгө	1 139 225 000,00	1 139 225 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11 342 058 592,50</u>	<u>13 010 076 876,54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>47 406 370,00</u>	<u>10 406 000,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР	47 406 370,00	10 406 000,00



	ТӨЛБӨР		
413	Өглөг	47 406 370,00	10 406 000,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00,00	2 800 000,00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12 422 783,00	00,00
4136	Бусад өглөг	34 983 587,00	7 606 000,00
41361	Байгууллагад төлөх өглөг	27 810 587,00	7 606 000,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7 173 000,00	00,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11 294 652 222,50</u>	<u>12 999 670 876,54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11 294 652 222,50	12 999 670 876,54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11 168 758 824,11	11 168 758 824,11
51101	Өмч: - төрийн	11 168 758 824,11	11 168 758 824,11
512	Хуримтлагдсан үр дүн	-2 817 063 760,61	-1 112 045 106,57
51210	Өмнөх үеийн үр дүн	-2 817 063 760,61	-2 817 063 760,61
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	1 705 018 654,04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2 942 957 159,00	2 942 957 159,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11 342 058 592,50</u>	<u>13 010 076 876,54</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9 043 839 173,02	12 702 726 910,51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	468 557 285,02	2 833 765 170,18
120	Нийтлэг татварын бус орлого	153 629 585,02	2 833 765 170,18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	153 629 585,02	2 833 765 170,18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	208 506 242,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	153 629 585,02	2 625 258 928,18
121	Хөрөнгийн орлого	314 927 700,00	00,00



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	314 927 700,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8 575 281 888,00	9 868 961 740,33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	595 305 388,00	255 791 522,33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189 254 684,00	00,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76 793 599,00	69 505 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	329 257 105,00	186 286 522,33
1330	Төсвийн захирагчдаас	4 506 577 100,00	5 473 811 400,00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4 506 577 100,00	5 473 811 400,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3 473 399 400,00	4 139 358 818,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3 473 399 400,00	4 139 358 818,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9 080 269 161,16	10 997 708 256,47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9 080 269 161,16	10 997 708 256,47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9 067 053 748,03	10 979 110 383,79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5 260 890 800,63	6 435 956 826,97
210101	Үндсэн цалин	3 243 290 501,95	3 952 000 126,97
210102	Нэмэгдэл	1 521 094 198,68	1 737 212 400,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	242 000 200,00	346 500 000,00
210104	Урамшуулал	254 505 900,00	400 244 300,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	628 476 092,01	805 060 646,15
210201	Тэтгэврийн даатгал	429 761 086,47	549 791 001,33
210202	Тэтгэмжийн даатгал	41 537 194,16	63 557 544,82
210203	ҮОМШӨ-ний даатгал	51 921 493,44	51 123 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	9 568 756,18	12 780 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	95 687 561,76	127 808 100,00



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	403 468 703,00	416 170 199,40
210301	Гэрэл, цахилгаан	92 457 154,00	110 225 501,00
210302	Түлш, халаалт	131 566 859,00	130 972 034,00
210303	Цэвэр, бохир ус	179 444 690,00	174 972 664,40
2104	Хангамж, бараа материалын зардал	141 620 887,23	142 832 001,52
210401	Бичиг хэрэг	21 936 543,00	20 869 806,00
210402	Тээвэр, шатахуун	70 345 280,20	61 805 475,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8 712 510,03	8 246 390,52
210404	Ном, хэвлэл	30 000,00	1 375 400,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8 593 520,00	34 722 540,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 342 050,00	14 692 390,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	27 660 984,00	00,00
210408	Бараа материал акталсны зардал	00,00	1 120 000,00
2105	Нормативт зардал	1 757 242 847,20	2 006 873 306,96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 559 057 964,16	1 788 724 090,51
210502	Хоол, хүнс	187 884 153,04	218 149 216,45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10 300 730,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64 482 066,00	97 577 010,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2 771 626,00	00,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	907 810,00	2 785 300,00
210604	Урсгал засвар	60 802 630,00	94 791 710,00
2107	Томилолт, зочны зардал	18 087 875,00	17 614 250,00
210702	Дотоод албан томилолт	18 087 875,00	17 614 250,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30 034 905,00	53 775 553,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 170 000,00	20 781 393,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900 000,00	900 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	4 808 400,00	909 100,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	271 000,00	271 000,00



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264 000,00	297 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10 329 000,00	7 404 000,00
210807	Газрын төлбөр	3 277 608,00	2 999 992,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	147 500,00	666 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8 867 397,00	19 546 568,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	762 749 571,96	1 003 250 589,79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1 188 000,00	44 796 059,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 975 000,00	12 730 460,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	757 586 571,96	945 724 070,79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 215 413,13	18 597 872,68
2132	Бусад урсгал шилжүүлэг	9 308 688,00	18 205 367,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9 308 688,00	18 205 367,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3 906 725,13	392 505,68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3 906 725,13	392 505,68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-36 429 988,14</u>	<u>1 705 018 654,04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	74 719 155,25	00,00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	69 594 627,25	00,00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	5 124 528,00	00,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-74 719 155,25	00,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-111 149 143,39</u>	<u>1 705 018 654,04</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		



1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8 572 006 888,00	10 077 467 982,33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00,00	208 506 242,00
120	Нийтлэг татварын бус орлого	00,00	208 506 242,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00,00	208 506 242,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	208 506 242,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8 572 006 888,00	9 868 961 740,33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	592 030 388,00	255 791 522,33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189 254 684,00	00,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76 793 599,00	69 505 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	325 982 105,00	186 286 522,33
1330	Төсвийн захирагчдаас	4 506 577 100,00	5 473 811 400,00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4 506 577 100,00	5 473 811 400,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3 473 399 400,00	4 139 358 818,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3 473 399 400,00	4 139 358 818,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8 572 006 888,00	10 077 467 982,33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8 572 006 888,00	10 077 467 982,33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8 558 181 474,87	10 054 928 409,65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5 234 044 146,68	6 443 951 665,79
210101	Үндсэн цалин	3 216 444 048,00	3 960 024 965,79
210102	Нэмэгдэл	1 521 094 198,68	1 737 182 400,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	242 000 000,00	346 500 000,00
210104	Урамшуулал	254 505 900,00	400 244 300,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	639 119 400,00	804 018 531,33
210201	Тэтгэврийн даатгал	639 119 400,00	548 402 331,33



210202	Тэтгэмжийн даатгал	00,00	63 904 100,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00,00	51 123 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	00,00	12 780 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	00,00	127 808 100,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	403 468 703,00	416 170 199,40
210301	Гэрэл, цахилгаан	92 457 154,00	110 225 501,00
210302	Түлш, халаалт	131 566 859,00	130 972 034,00
210303	Цэвэр, бохир ус	179 444 690,00	174 972 664,40
2104	Хангамж, бараа материалын зардал	145 629 542,63	156 894 365,52
210401	Бичиг хэрэг	12 682 609,00	15 032 078,00
210402	Тээвэр, шатахуун	59 568 699,00	67 885 051,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8 712 510,03	8 247 410,52
210404	Ном, хэвлэл	897 990,00	1 375 400,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26 270 360,00	34 722 540,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37 497 374,60	29 631 886,00
2105	Нормативт зардал	1 818 371 861,95	1 940 460 704,61
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 562 885 931,95	1 677 137 228,11
210502	Хоол, хүнс	194 233 730,00	222 668 866,50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	61 252 200,00	40 654 610,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	261 152 731,61	157 139 521,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	203 190 825,00	46 053 366,00
210602	Тавилга	00,00	9 996 800,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2 785 300,00	2 785 300,00
210604	Урсгал засвар	55 176 606,61	98 304 055,00
2107	Томилолт, зочны зардал	18 087 875,00	17 614 250,00
210702	Дотоод албан томилолт	18 087 875,00	17 614 250,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32 160 464,00	52 430 103,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 170 000,00	21 651 393,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	900 000,00	900 000,00



	ТОГТООХ		
210803	Даатгалын үйлчилгээ	4 808 400,00	909 100,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	271 000,00	271 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264 000,00	297 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11 014 000,00	7 404 000,00
210807	Газрын төлбөр	1 728 500,00	5 550 100,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	147 500,00	666 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11 857 064,00	14 781 010,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6 146 750,00	66 249 069,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1 888 000,00	49 214 559,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 258 750,00	17 034 510,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 825 413,13	22 539 572,68
2132	Бусад урсгал шилжүүлэг	9 918 688,00	22 147 067,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9 918 688,00	22 147 067,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3 906 725,13	392 505,68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3 906 725,13	392 505,68
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00,00</u>	<u>00,00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагд-сан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	--------------------	--



C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9 559 678 492,11	972 396 203,26	-2 888 733 567,22	7 643 341 128,15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	182 818 950,00	182 818 950,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9 559 678 492,11	972 396 203,26	-2 705 914 617,22	7 826 160 078,15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	1 609 080 332,00	00,00	-111 149 143,39	1 497 931 188,61
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11 168 758 824,11	2 942 957 159,00	-2 817 063 760,61	11 294 652 222,50
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11 168 758 824,11	2 942 957 159,00	-2 817 063 760,61	11 294 652 222,50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11 168 758 824,11	2 942 957 159,00	-2 817 063 760,61	11 294 652 222,50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00



D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	1 705 018 654,04	1 705 018 654,04
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11 168 758 824,11	2 942 957 159,00	-1 112 045 106,57	12 999 670 876,54

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9 821 791 200,00	9 821 676 460,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9 821 791 200,00	9 821 676 460,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9 810 791 200,00	9 810 287 989,32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6 440 169 700,00	6 439 751 665,79
210101	Үндсэн цалин	3 960 443 000,00	3 960 024 965,79
210102	Нэмэгдэл	1 737 182 400,00	1 737 182 400,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	346 500 000,00	346 500 000,00
210104	Урамшуулал	396 044 300,00	396 044 300,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	798 800 700,00	798 800 700,00
210201	Тэтгэврийн даатгал	543 184 500,00	543 184 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	63 904 100,00	63 904 100,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	51 123 200,00	51 123 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	12 780 800,00	12 780 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	127 808 100,00	127 808 100,00
2103	Байр ашиглалттай холбоотой	416 170 200,00	416 170 199,40



	тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	93 169 700,00	110 225 501,00
210302	Түлш, халаалт	139 109 300,00	130 972 034,00
210303	Цэвэр, бохир ус	183 891 200,00	174 972 664,40
2104	Хангамж, бараа материалын зардал	104 508 600,00	104 494 604,52
210401	Бичиг хэрэг	3 281 800,00	2 966 603,00
210402	Тээвэр, шатахуун	54 902 800,00	54 902 691,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7 842 700,00	7 951 210,52
210404	Ном, хэвлэл	00,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31 462 100,00	31 462 100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7 019 200,00	7 212 000,00
2105	Нормативт зардал	1 937 914 200,00	1 937 892 320,61
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 654 868 400,00	1 675 512 228,11
210502	Хоол, хүнс	246 400 000,00	221 725 482,50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36 645 800,00	40 654 610,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40 227 200,00	40 179 390,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16 709 900,00	16 694 210,00
210602	Тавилга	10 000 000,00	9 996 800,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2 785 300,00	2 785 300,00
210604	Урсгал засвар	10 732 000,00	10 703 080,00
2107	Томилолт, зочны зардал	14 568 600,00	14 568 600,00
210702	Дотоод албан томилолт	14 568 600,00	14 568 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32 432 000,00	32 431 900,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2 300 000,00	2 300 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900 000,00	900 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	909 100,00	909 100,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228 900,00	228 900,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	265 500,00	265 500,00



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7 404 000,00	7 404 000,00
210807	Газрын төлбөр	5 550 100,00	5 550 100,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	666 600,00	666 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14 207 800,00	14 207 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26000000,00	25998609,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26 000 000,00	25 998 609,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11000000,00	11388470,68
2132	Бусад урсгал шилжүүлэг	11 000 000,00	10 999 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11 000 000,00	10 999 000,00
213303	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		389470.68
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9 821 791 200,00	9 821 676 460,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5 473 811 400,00	5 473 811 400,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5 473 811 400,00	5 473 811 400,00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4 139 479 800,00	4 139 358 818,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4 139 479 800,00	4 139 358 818,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	208 500 000,00	208 506 242,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	208 500 000,00	208 506 242,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	500,00	500,00
620001	Удирдах ажилтан	02,00	02,00
620002	Гүйцэтгэх ажилтан	308,00	308,00
620003	Үйлчлэх ажилтан	190,00	190,00